



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 дугаар сарын 29

Дугаар 19/03

Баян-Өндөр сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, 20.1.7, 20.1.9, 20.1.18, 20.1.21, 20.1.22, 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.15 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, аймгийн Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргалд ДААЛГАХ нь:

2.1. Өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж ажиллуулах;

2.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, явцын талаарх мэдээллийг 2024 оны 08 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд танилцуулах.

ДАРГА



Д.МӨНХБАТ